



Шинжээчийн тайлан

Хөтөлбөрийн нэр: Аялал жуулчлалын менежмент

Индекс: (D041304)

Байгууллагын нэр: ШУТИС

Шинжээчийн баг:

Ахлагч: М.Хишиг-Ундрах

Гишүүд: С.Амаржаргал

Ц.Дашцэрэн

2022.06.03

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр	Шинжлэх ухаан технологийн их сургууль	
Сургалтын хөтөлбөрийн	Аялал жуулчлалын менежмент	
Индекс	D 041304	
Шинжээчид	<ol style="list-style-type: none"> 1. Овог нэр: Мижгээ Хишиг-Ундрах (Ph.D), Дэд профессор Ажил албан тушаал: Сэтгэл зүйн үйлчилгээний төвийн эрхлэгч Ажлын газар: МУБИС 2. Овог нэр: С.Амаржаргал Ажил албан тушаал: (Ph.D), Ахлах багш Ажлын газар: Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль 3. Овог нэр: Ц.Дашцэрэн Ажил албан тушаал: Соёл иргэншил, аялал жуулчлалын тэнхимийн багш Ажлын газар: Санхүү эдийн засгийн их сургууль 	
БМИУЗ-ийн Мэргэжилтэн	БМИУЗ-ийн зохицуулагч: Г6Даваажаргал (Ph.D, дэд профессор)	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2022.05.11	Ажлын албаны захирлын тушаал 2022 №А/101
	2022.05.11	- Шинжээчидтэй гэрээ байгуулах Гэрээ №27/2022 - Шинжээчийн ёс зүйн шаардлага - Ажлын хуваарьтай танилцсан - Шинжээчийн тайлан бичих - Шинжээчид өөрийн үнэлгээний тайланг хүлээн авсан.
	2022.05.18	- Шинжээчид урьдчилсан үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө.
	2022.05.23, 24	- Төлөвлөгөөний дагуу сургууль дээр очиж шинжээчид
	2022.06.02	- Шинжээчид үнэлгээний тайланг мэргэжилтэнд хүлээлгэн өгнө. сургуульд илгээж санал авна.
	2022.06.03	- Шинжээчид үнэлгээний тайланг эцэслэнэ.
	Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар шинжээчийн үнэлгээний тайланг танилцуулж шийдвэрлүүлнэ.	

II. Сургалтын хөтөлбөрийн товч танилцуулга

Хөтөлбөрийн нэр, индекс	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
Аялал жуулчлалын менежмент D 041304	Л.Амартүвшин	Өдөр	4 жил	125

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж, өсөн нэмэгдэж буй эрэл хэрэгцээ, түүнтэй уялдан гарч буй хууль тогтоомж, эрх зүйн бусад баримт бичгүүд, төрөөс баримтлах бодлогыг авч үзээд эдгээрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлд шинжилгээ хийж, олон улсын болон Монголын аялал жуулчлал сэргэх таамаглал менежментийн зураглалыг гаргасан байна.
- Сургалтын хөтөлбөрийг түүнд тавигддаг шаардлагуудын дагуу боловсруулж, шат, шатны хөтөлбөрийн хороо, эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, сайжруулсан тэмдэглэлүүд, байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байна.
- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө, /матриц/ Аялал жуулчлалын менежмент D041304 хөтөлбөр байна.
- Хөтөлбөрийг гадаад (2) болон өөрийн орны (3) ижил төстэй сургалт явуулдаг их сургуулиудын хөтөлбөрүүдтэй харьцуулан судалсан байна. Судалгаанд үндэслэн хөтөлбөрийг шинэчлэн, боловсролын чиг хандлага, мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцэхүйц боловсруулсан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Аялал жуулчлал менежментийн хөтөлбөрөөр суралцагчдын мэргэжлийн дадлагыг Япон улсын аялал жуулчлалын сүлжээ компаниудад цалинтай ажиллуулж, дадлагажуулж байна.

Анхаарах асуудал:

- ШУТИС-ийн “Аялал жуулчлалын менежмент” -ийн хөтөлбөрийн онцлог, бусад ижил төстэй хөтөлбөрөөс ялгагдах онцлогийг тодотгох

Зөвлөмж:

- Гадаад оюутан элсүүлэх бодлого, үе шаттай ажиллах төлөвлөгөө боловсруулах.

Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-2030 хөгжлийн стратеги төлөвлөгөө, өөрийн салбар БУХС-ийнхаа эрхэм зорилго, бодлогын баримт бичгийн үзэл санаа, стандартын дагуу “Аялал жуулчлалын менежмент” бакалаврын хөтөлбөрийн зорилго, зорилтыг тодорхойлж, төгсөгчийн загвар-ыг тодорхойлсон байна.
- БСШУС-ын сайдын 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаалаар баталсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ыг үндэслэн энэ хөтөлбөрийн хүрээнд тавигдаж буй үндсэн зорилтуудыг, төгсөгчдийн эзэмших ур чадварыг өөрийн үнэлгээний тайлангийн 17-р хуудсанд дэлгэрэнгүй тодорхойлж, 18-р хуудасны Хүснэгт 6-д хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, чадвар, хандлагуудыг харуулсан байна.
- МУЗГ-аас “Төрөөс аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого (2019.08.21)
- Хөтөлбөрийн сургалтын зорилтууд ба үр дүнгүүд
- Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын болон Монгол улсын аялал жуулчлалын салбарын өнөөгийн зураглалыг гаргасан байна.

Анхаарах асуудал:

- Инженерийн боловсролын шинэчлэлийн CDIO стандарт, арга зүйн загвар, БУСТА загварууд АЖМ-ийн хөтөлбөрт хэрхэн тусгагдсаныг тодруулах

Зөвлөмж:

- Цаашид хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинэлэг, бүтээлч хандлага (инновац)-ыг бий болгох, ийм эрэл хайлт хийх.

Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ны Сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага
- Аялал жуулчлалын менежмент мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөр, *стандартууд 2014; 2016*
- Магадлан итгэмжлэлийн тайланг хэлэлцүүлсэн салбарын хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадварын жагсаалт ба хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтууд, хичээлүүдийн хоорондын уялдаа, холбоог харуулсан байна. (ӨҮТ 26 хуудас)
- Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрөөр төгсөгчийн буюу мэргэжилтний загвар, тодорхойлолт
- БМИҮЗ-ийн шинжээчдийн өгсөн зөвлөмжийн дагуу хийгдсэн ажлуудын товчоон
- Сургалтын хөтөлбөрийн төлөвлөлтөд хийсэн SWOT шинжилгээ

Онцлог зүйл/Туршлага:

- Аялал жуулчлалын холбоодуудтай хамтран төгсөгчид, ажил олгогчдын уулзалт, семинар, уралдаан, онол практикийн хурал, мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулдаг.

Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын менежмент бакалаврын сургалтад олон улсад нийтлэг хэрэглэдэг сурах бичгүүдийг орчуулахад анхаарах

Шаардлага:

- Хөтөлбөрт дадлагын төрөл хэлбэр, цагийг нэмэгдүүлэх боломжийг судалж, дадлагын кредит цагийг нэмэгдүүлэх
- Аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэж байгаа хөтөлбөрийн онцлогийг харгалзан суралцагчдад англи хэлний хичээлийг тасралтгүй судлах болон 2 хэл үзэж судлах боломжийг судалж, сургалтын төлөвлөгөөнд тусгах, хэрэгжүүлэх

Шаардлагыг хангасан байдал: ***Хэсэгчлэн хангасан***

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан**

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Аялал жуулчлалын менежмент” D041304 бакалаврын сургалтын хөтөлбөр нь БСШУЯ-ны 2003 оны 5 сарын 23-ны өдрийн 181 тоот тушаалаар батлагдсан. Сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл;
- ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам <https://www.must.edu.mn/page/430>
- АЖМ мэргэжлийн хичээлүүдийн хөтөлбөрийг ШУТИС-ийн ЭЗ-ийн 2019.06.17 өдрийн хурлаар шинэчлэн баталсан;
- АЖМ мэргэжлийн хөтөлбөр дэх хичээл бүрийн холбоо хамаарлын матриц /эзэмших үр чадварууд CDIO аргын 2-р түвшин/
- АЖМ мэргэжлийн хөтөлбөр дэх хичээл бүрийн холбоо хамаарлын матриц БУСТА загвар /Бизнесийн удирдлагын сургалтын төлөвлөгөөний алгоритм/
- Cloud university мэдээллийн систем
- Хичээл сонголтын нэгдсэн хуанли <https://www.must.edu.mn/page/209>
- Суралцагчийн цагийн ачааллыг (125 кр) нэг улиралд 8-20 кр судлахаар зохистой тооцжээ.

Онцлог зүйл/Туршлага

- Сургалтын агуулгыг үр дүнд суурилсан боловсрол болон олон улсын инженерийн боловсролын шинэчлэлийн “CDIO” зэрэг сургалтын дэвшилтэд аргууд, олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага (ACBSP)-ын шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн уламжлал, дотоод нөөц боломжтойгоо уялдуулан сургалтын төлөвлөгөөний БУСТА алгоритмын дагуу хөтөлбөрийг шинэчлэн боловсруулсан сургалтын үйл ажиллагааг явуулдаг.

Анхаарах асуудал:

- Хичээл тус бүрд сэдвийн агуулгын давхардал бий эсэхийг хөтөлбөр хэрэгжүүлэх багш нар хамтран хэлэлцэх

Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- БСШУЯ-ны Сайдын А/174 тоот тушаалаар батлагдсан Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага;
- Сургалтын арга зүйн CDIO загвар (*Зураг-2.11*)
- Судалгаанд үндэслэн сургалтад ашиглаж буй сургалтын идэвхтэй, түгээмэл ашигладаг аргуудын жагсаалт, судалгааны үр дүн (*Хүснэгт- 2.16; 2.18; 219*)
- Cloud university мэдээллийн систем
- Сургалтад ашиглагдаж байгаа программ хангамжийн судалгаа (*Хүснэгт 2.21*)
- Цахим сургалтын тайлан
- Багш нар лекц, хэлэлцүүлэг, тонгоруу арга, ойлголтын асуулт, багаар хамтрах, бие биедээ заах, дүрд тоглох зэрэг аргуудыг ашиглан сургалтын үйл ажиллагааг удирдан явуулдаг арга, хэлбэрийг *Хүснэгт 2.30-д* үзүүлсэн байна.

Онцлог зүйл/Туршлага:

- “Аялал жуулчлалын менежмент мэргэжлийн хөтөлбөрийн сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй. Нээлттэй хичээл, сургалт арга зүйн семинар зохион байгуулж, үйл ажиллагаа нь тогтмолжсон.

Анхаарах асуудал:

- Өөрийн үнэлгээний тайлан, хичээлийн цөм хөтөлбөрт мэргэжлийн онцлогоо илүү тодорхойлж тусган, арга бүрийг илүү ойлгомжтой дэлгэрэнгүй бичих (Зорилго, зорилт, үр дүн, үйл явц, ашиглах материал)

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн, хичээлийн үр дүнг матрицаар боловсруулж бичсэн нь сайн талтай ч түүнийг цогцоор нь хэрхэн заах, үнэлэх чадамжийг (мэдлэг, чадвар, хандлагыг) үнэлэх арга зүйг сургалтад ашиглах
- Юу заах нь чухал ч хэрхэн заах нь түүнээс илүү чухал тул ялангуяа Заахуйгаас суралцахуйд шилжихэд багш нарт зориулсан сургалт, хэлэлцүүлэг хэрхэн явагддаг, туршлагаа хэрхэн солилцож залуу үедээ өвлүүлдэг талаар тусгавал маш олон бүтээлч, сайн туршлага болохоор санаа авах нөхцөл бүрдүүлэх

Шаардлагыг хангасан байдал: ***Бүрэн хангасан***

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Ректорын *А/64 тоот тушаал*
- ШУТИС-ийн дотоод хяналт шалгалтын журам
- ШУТИС-ийн *А/134 тоот*
- Үр дүнд суурилсан боловсролын сургалтын үнэлгээний загвар
- ШУТИС “70+30” үнэлгээний системийг хэрэглэдэг.

- Оюутнуудаас сургалтаар олж авсан мэдлэг, чадварын талаарх сэтгэл ханамжийн судалгааг авч, Лайкертын 5 баллаар үнэлэхэд 3,98 дундажтай гарсан байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын мэдлэг, дадал, чадварыг үнэлдэг тогтолцоо бүрэлдсэн байна.
- Хөндлөнгийн хяналт бүрдсэн гэж үзэж байна.
- Тухайн улиралд “хангалтгүй” суралцсан оюутныг (0.7-оос доош голчтой) “Анхааруулгын хуудас”-нд бичиж сануулдаг.

Зөвлөмж:

- Суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх тест, даалгаврыг /сэргээн санах, ойлгох, хэрэглэх, задлан шинжлэх, үнэлэх, бүтээх/ түвшинчлэн хичээл бүрээр боловсруулах
- Оюутны хандлагыг үнэлэх тусгай аргуудаас сургалтад ашиглах

Шалгуурыг хангасан байдал: ***Бүрэн хангасан***

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан**

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Материаллаг баазын бэхжилтийн хувьд БЗД-ийн 2-р хороо, Их тойрууд өөрийн эзэмшил газарт сургалтын зориулалт бүхий 8064м² талбай бүхий хичээлийн байр, 6648м² оюутны байранд үйл ажиллагаа явуулж байна.
- ХБИ-д зориулсан ариун цэврийн өрөө, цахилгаан шат, тэргэнцэртэй явах шатыг иж бүрэн тохижуулсан байна.
- Бүх анги танхимыг проектор, самбараар иж бүрэн тоноглогсон байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Аялал жуулчлалын мэргэжлийн кабинетыг өөрсдийн дотоод нөөц бололцоогоор тохижуулж сургалтад ашигладаг.
- Идэвхтэй сургалтын танхим нээж оюутанд үйлчилдэг..
- Оюутан залуусын гарааны бизнесийг дэмжих дундын оффисыг бий болгосон.
- Сургалтын үйл ажиллагаа, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх зорилтын хүрээнд тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчин ашиглах нөхцөл бүрдсэн.

Шаардлагыг хангасан байдал: ***Бүрэн хангасан***

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Сургалтын багц материал боловсруулах цахим удирдамж /MS-teams/
- Хичээлийн хөтөлбөр боловсруулах журам
- Сургалтын хэрэглэгдэхүүнд зориулсан хөрөнгө оруулалтын хэмжээ хэвийн тасралтгүй явагддаг (хүснэгт 3.6)
- Лабораторийн тоног төхөөрөмжийн жагсаалт, ашиглаж буй программ хангамж (Хүснэгт 3.7, хүснэгт 3.8) -тай байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Багш нар цахим хичээлийн агуулгыг идэвхтэй боловсруулж, сургалтад бүрэн нэвтрүүлэн хэрэглэж байна.
- Лекц семинарын анги танхмыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглон, сургалтын таатай орчныг бүрдүүлсэн.
- Магистрантуудад үйлчлэх тусгай танхимтай
- Сургалтын хэрэглэгдэхүүний захиалгыг хичээлийн жилийн эхэнд багш бүр бичгээр өгч шийдүүлдэг.

Анхаарах асуудал:

- Цахим сургалтыг зохион байгуулахдаа хэт олон төрлийн платформ ашиглаж байна. Ингэснээр интернетийн орчинд суралцах суралцагчдад хэт их ачаалал үүсэх, хичээл зааж буй багшаас хамааран оюутнууд төрөл бүрийн программ хангамж, платформ ашиглах шаардлага үүсэж болзошгүйг цаашид анхаарах;

Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- MNS5742:2007-г мөрдлөг болгон ажилладаг.
- Lib4u программ түрээслэн ашигладаг.
- Номын сангаас нэвтэрч болох цахим эх сурвалжуудыг жагсаалт (DOAB, THESESES, Springer Nature, EBSCO, багш нарын бүтээлийн ном зүйт).
- 50.000 номын фонд бүхий 7000м² ашиглалтын талбайд үйл ажиллагаа явагдаж нийт 56 хүний бүрэлдэхүүнтэй үйлчилж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим номын сангийн эрдэм шинжилгээний E-уншлагын танхимыг бий болгож, суралцагчид бие даан суралцах, судалгааг хийх орчин нөхцөлийг бүрдүүлсэн.

- Багш нарын бүтээлийг олон тоотойгоор худалдан авч сургалтад ашигладаг.
- Ном хайлтын киоск үйлчилгээг давхар бүрт байрлуулж үйлчилдэг.
- Ном ариутгагч төхөөрөмж 2 ширхгийг суурилуулж ариутгал хийх бөгөөд эрүүл ахуйн нөхцөлийг шийдэж өгсөн.
- Аялал жуулчлалын чиглэлийн гадаад номын баяжилт сайн хийгдсэн

Анхаарах асуудал:

- Монгол хэл дээрх мэргэжлийн зарим сурах бичгийн хүрэлцээ хангалтгүй

Зөвлөмж:

- Мэргэжлийн хичээлүүдийн үндсэн сурах бичгийн жагсаалтыг нэгтгэж суралцаж буй оюутны хэмжээнд хүрэлцээтэй байгаа эсэхийг жил бүр судлан үзэж, хэрэгцээтэй сурах бичгийн фондыг бий болгох тал дээр төлөвлөж ажиллах;

Шаардлагыг хангасан байдал: ***Бүрэн хангасан***

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан**

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд /А/32 тушаал/
- Хичээлийн хөтөлбөрийн багийн хурлын тэмдэглэлүүд
- Эрдмийн зөвлөлийн хурлын тэмдэглэл, захирлын тушаал
- Сургалтын өдөр тутмын үйл ажиллагаа шуурхай удирдлагаар хангах CLOUD UNIMIS мэдээллийн системийг хэрэглэж эхэлсэн байна.
- 2018.01.31-ний өдрийн тушаалаар Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба байгуулж олон улсын стандарт ISO9001:2015 болон 21001:2018 нэвтрүүлж, чанарын үнэлгээний албыг ажиллуулж байна.

Онцлог зүйл/Туршлага:

- Хичээлийн хөтөлбөрийн багуудын үйл ажиллагаа жигдэрсэн, хичээлийн хөтөлбөрийн сайжруулалтыг хичээлийн хөтөлбөрийн багаар тасралтгүй гүйцэтгэдэг.
- 2018.01.31-ний өдрийн тушаалаар Чанарын хяналт шинжилгээ, үнэлгээний алба байгуулж олон улсын стандарт ISO9001:2015 болон 21001:2018 нэвтрүүлж, чанарын үнэлгээний албыг ажиллуулж байна.

- Хөтөлбөрийн үйл ажиллагаа төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох шинэ хэлбэрт шилжсэн.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн удирдлагын зүгээс орчин, тэр дундаа оюутны дотуур байрны нөхцөлийг сайжруулах чиглэлд санаачилгатай ажиллах

Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Хамтран ажилладаг байгууллагууд. Үүнд: Европын холбооны “Ерасмус” хөтөлбөр хэрэгжүүлэх эрхтэй, Тайваны үндэсний ИС-ийн IMBA 1+1 магистрын хамтарсан, БНСУ-ын Улсан, Кумо, Сунгшил ИС бакалаврын хамтарсан, Болгарын Варна ИС, багш, оюутан солилцоо, Туркийн Докуз Эелил ИС;
- Хамтран ажилладаг байгууллагуудаас зохион байгуулдаг уралдаан, тэмцээнд оролцдог. Аялал жуулчлалын Grand tour.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин жуулчны бааз, тур оператор компаниудтай хамтран ажилладаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төвийг ажиллуулж, тайлан мэдээлэл гаргадаг.
- Гадаадын зочин профессор ажиллуулдаг

Анхаарах асуудал:

- Шалгуур 4.2 хэсгийн багш, суралцагчийн оролцсон төсөл, хөтөлбөрийн мэдээллээр баяжуулах

Зөвлөмж:

- Төсөл, хөтөлбөрт хамрагдах оюутны оролцоо, тоог нэмэгдүүлэх

Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан**

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- 2016-2020 оны орлогын төсөв ба гүйцэтгэлийг орлогын эх үүсвэр бүрээр ангилж гаогасан (Хүснэгт 4.6)
- Санхүүгийн тайлангийн шинжилгээг хийж үзүүлсэн (Хүснэгт 4.8)
- Оюутны үйлчилгээ, нэг оюутанд ногдох өртөг, зардлын мэдээг үзүүлсэн (Хүснэгт 4.11)

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээ, хичээл, практикийн зардал сүүлийн 5 жилд тасралтгүй өссөн байна. (Хүснэгт 4.13, 4.14)
- Төсөл болон гэрээт ажил гүйцэтгэн нэмэлт орлого төвлөрүүлэн ажиллаж байна.

Анхаарах асуудал:

- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тэнхим, сургуульд оруулж буй орлого, зардлын тооцоог хийх

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр суралцагчдад дэмжлэг үзүүлэх санхүүгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх;

Шаардлагыг хангасан байдал: ***Бүрэн хангасан***

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- 2017 оноос Маркетинг олон нийттэй харилцах албыг байгуулж үйл ажиллагаа явуулж байгаа
- Зар сурталчилгаа, маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр хийдэг ажлуудыг үзүүлсэн (Хүснэгт 4.19)
- Нээлттэй хаалганы өдрүүдийг ШУТИС болон Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийн идэвхжүүлэлтийн зорилгоор зохион байгуулдаг.

Онцлог зүйл/Туршлага:

- Цахим сурталчилгаанд МҮОНРТ-тэй хамтарсан цуврал нэвтрүүлэг, подкаст 86-г бэлтгэн түгээсэн (Хуудас 135)
- Хөтөлбөрийн таниулах, сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулдаг нь холбогдох нотлох баримтаар харагдаж байна. Мөн цахим сурталчилгааг бэлтгэн түгээдэг.

Анхаарах асуудал:

- Идэвхжүүлэлтийн үр дүнгийн судалгаа гаргах.

Зөвлөмж:

- Маркетингийн баг сурталчилгаа, идэвхжүүлэлтийн үр дүнд хариу өдөөгдөл хэр илэрч байгааг үнэлдэг байх.

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн нээлттэй ил тод байдлыг хангах нэгэн хэрэгсэл нь тус сургуулийн цахим хаяг болох <http://must.edu.mn.mn/> хаяг болон Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн (<http://www.sbh.edu.mn.mn>) хаяг байна. Тус хаягуудаар нэвтэрч хичээл заах багшийн талаар мэдээлэл авах боломжтой байна.
- Аялал жуулчлал менежмент хөтөлбөрийн олон нийтийн пейж хуудсыг 2018 оноос хөгжүүлж ажиллаж ирсэн
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагаа тогтмолжсон бөгөөд өөрийн цахим хуудастай

Онцлог зүйл/Туршлага:

- Маркетинг, олон нийттэй харилцах алба нь дараах чиглэлээр гэрээ байгуулан хамтарч ажилладаг байна. Үүнд:
 - Гэрээ байгуулсан өдөр тутмын сонин-6
 - Гэрээ байгуулсан телевиз-2
 - Веб сайт-3

Зөвлөмж:

- Ажил олгогчдын сэтгэл ханамжийг судлан анхаарах зүйлсийг нээлттэй хэлэлцэн шийдвэрлэдэг байх

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан***

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, БШУЯ-ны сайдын тушаал А/79 (2013), А/194 (2018), А/195 (2018)
- ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт оюутан элсүүлэх журам /2016-2017 (2016.6.22/02), 2017-2018 (2017.6.12/14), 2018-2019 (2018.5.25/08), 2019-2020 (2019.6.3/05), 2020-2021 (2020.5.27/06)/, ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам (2014.4.14 А/64)
- ШУТИС, БУХС-ийн сургалтын албаны мэдээлэл, Сургалтын бодлого зохицуулалтын газрын мэдээлэл

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчдын амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг үр дүнтэй, журмаар зохицуулагдсан тогтолцоотой, тодорхой системтэйгээр хэрэгжүүлж байна.
- Тухайн оюутан өөрийн оюутны программаар дамжуулан шаардлагатай мэдээллээ авах, хичээлээ үзэх, дүрэм журамтай танилцах, санал хүсэлтээ илгээх зэрэг бүхий л боломжоор хангаж өгдөг удирдлагын мэдээллийн системтэй.
- Тухайн үйлчилгээ, дэмжих үйл ажиллагааны үйл явцын зураглалыг RACI матрицийн хамтаар маш сайн гаргаж өгсөн.
- Оюутанд зөвлөн туслах үйлчилгээ, тэдгээрийн үүрэг чиглэл тодорхой, шинээр элссэн суралцагчдыг мэдээлэл, гарын авлагаар бүрэн хангаж, чиглүүлэх сургалтыг зөвлөх багш, хөтөлбөр хариуцсан тэнхим нэгж, Сургалтын алба, ОХУА жил бүр тогтмол зохион байгуулж хэвшсэн.
- Хөтөлбөр сурталчилах олон талт үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг.
- Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрөөр элсэгчдийн ЭЕШ-ийн дундаж оноо 506 гэсэн үзүүлэлттэй байна.

Зөвлөмж:

- Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрөөр гадаад оюутан суралцуулах талд дээр бодлогоор дэмжих
- Төгсөгчдийн холбоог идэвхжүүлэх, эргэх холбоогоор сайн хангаж өгөх

Шаардлагыг хангасан байдал: Бүрэн хангасан

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- МУ стандарт, Оюутны байрны үнэлгээ MNS 5869:2008
- Зөвлөх багшийг томилсон захирлын тушаал (2021.10.4 А/30), ШУТИС-ийн Ажлын байрны тодорхойлолт (2012), ШУТИС-ийн оны шилдэг багш шалгаруулах журам (2016.9.6 А/131), Оюутны онлайн хэлбэрийн гарын авлага (soft file), Багш оюутан хөтөлбөр (soft file), Оюутны үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөө хуанли (soft file)
- Сэтгэл ханамжийн судалгааны тайлан, БУХС-ийн их эмчийн тайлан, Сэтгэл зүйн төвийн тайлан, Алтангадас клубын тайлан (2022.5.18)

Онцлог зүйл/Туршлага:

- ОХУА-наас Оюутны үйлчилгээний нэгдсэн төлөвлөгөөг гаргаж, хэрэгжүүлж хэвшсэн.

- Сэтгэл ханамжийн судалгааг Зөвлөх багш, Сургалтын алба, Оюутны байр, Эмнэлгийн үйлчилгээ, Их эмчийн үйлчилгээ зэрэг үйлчилгээний төрлөөр авч хэвшсэн.
- Оюутны эрдэм шинжилгээний хуралд Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийн оюутнуудын оролцоо жил бүр нэмэгдэж байгаа үзүүлэлттэй.

Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийн зөвлөх багш нарын мэдээлэл, зөвлөн туслах ажлын төлөвлөгөөтэй байх.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2011), ЗГ-ийн 102–р тогтоол (2011), Дээд боловсролын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам (2014)
- ШУТИС-ийн оюутнуудад кредитийн урамшуулал олгох журам (2017.11.29 А/223), Ректорын нэрэмжит тэтгэлэг (2016.6.10 А/86), Авьяастныг дэмжих түр журам (2020.11.4 А/182)
- БУХС-ийн хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлан 2015-2018, БУХС-ийн Оюутны зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2015-2018, БУХС-ийн санхүүгийн тайлан 2014-2018, Алтангадас клубын тайлан 2022.

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчид сайн дурын клубын үйл ажиллагааг тогтмол явуулдаг ба хөтөлбөрийн дэргэдэх Алтангадас клубын үйл ажиллагаа жигдэрсэн.
- Суралцагчийн нийгмийн сайн дурын үйлчилгээг үнэлэх, мөн гаргасан амжилтыг урамшуулж үнэлэх журмаар зохицуулагдсан системтэй. Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийн 30 оюутан уг урамшууллын багц цагийн авсан байна.
- Оюутны үйлчилгээний зардал, урамшуулал, тэтгэлэг, хөнгөлт олгосон хэмжээ өсөлттэй үзүүлэлттэй.

Анхаарах асуудал:

- Япон улсад дадлага хийгээд ирсэн оюутнуудын буцаад сургуульдаа ирж сурч байгаа хувь, дадлагын тооцуулсан багц цагийн судалгааг хийж, хяналт тавьж байх

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн оюутны ёсзүйн дүрэм (2012.10.11 А/143), ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам (2014.4.14 А/64)

Онцлог зүйл/Туршлага:

- Шилжих хөдөлгөөний урсгал эерэг баланстай буюу 2020 онд +2, 2021 онд +3 гэсэн үзүүлэлттэй гарсан нь сайшаалтай.
- Суралцагчийн шилжилт хөдөлгөөн, багц цаг дүйцүүлэн тооцох тусгайлсан журамтай.

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- Дээд боловсролын диплом олгох журам (2006)
- ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам (2014.4.14 А/64)
- ШУТИС-ийн ректорын тушаал (2014.4.14 А/64)

Онцлог зүйл/Туршлага:

- Холбогдох журмын дагуу хэвийн олгогдож байна.

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан***

Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Монгол улсын боловсролын тухай хууль (2002), Дээд боловсролын тухай хууль (2002)
- ШУТИС 2030 Стратеги төлөвлөгөө (2020), ШУТИС-ийн дүрэм (2017.5.16/ 11), ШУТИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам (2022.1.5 А/02), Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам (2021.12.14 А/234), Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журам (2021.12.14 А/234), Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам (2022.1.13 А/05), Профессор багш, ажилтан, ажилчдыг шагнаж урамшуулах журам (2010.4.2/ 116), ШУТИС-ийн оны

шилдэг багш шалгаруулах журам (2016.9.16 А/131), Дотоод хяналт шалгалтын журам (2009.5.1/ 162)

Онцлог зүйл/Туршлага:

- Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Технологи Менежментийн Салбарт 25 багш харъяалагдаж, түүний 85.2 % нь 10-с дээш жил ажилласан туршлагатай, сургалтын арга зүй, мэргэжлийн ур чадвар бүхий хүний нөөцтэй байна.
- ШУТИС-ийн Стратеги төлөвлөгөөнд стратегийн зорилт 1.5, 2.1 5.4-д хүний нөөцийн хөгжлийн зорилт, түүнийг хангах стратеги, үр дүнг тодорхойлж өгсөн бөгөөд энэ талаар 26 дүрэм, журам мөрдөгдөж байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн ТМС-ийн 43.5 хувь нь докторын зэрэгтэй.

Анхаарах асуудал:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээл ордог багш нарын эрдэмжилт, судалгаа шинжилгээ зэрэг Б цагийн гүйцэтгэлд анхаарах

Зөвлөмж:

- Докторын зэрэгтэй мэргэжлийн багшийн эзлэх хувийн жинг нэмэгдүүлэхэд анхаарах

Шаардлагыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- БУХС-ийн тайлан 2016-2021, Багшийн хөгжлийн төвийн тайлан 2021, ТМС-ийн урамшууллын тайлан 2021, ТМС-ийн Багшийг гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлж чадавхжуулсан судалгаа 2021

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн төв болон багийн ажиллуулснаар багш, ажилчдын эрэлт хэрэгцээ, шаардлагыг хангахад эерэг нөлөөлж байна.
- Багшийг хөгжүүлэхэд зориулж тухайн жилийн сургалтын орлогын 2-5 хувийг зарцуулж байгаа нь бодит урамшуулал болж байна.
- Ахмад багшаа дагалдан сурдаг, хамтарч хичээл ордог уламжлалтай.

Зөвлөмж:

- Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа урьдчилан хийдэг болох

Шаардлагыг хангасан байдал: Бүрэн хангасан

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам (2022.1.13 А/05), ТМС-ийн Б, В цагийн гүйцэтгэлийн тайлан 2017-2021

Онцлог зүйл/Туршлага:

- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулах төсвийн хэмжээ тогтмол өсөж байгаа үзүүлэлттэй.
- Профессор, багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих эрх зүйн орчин бүрдсэн.
- Аялал жуулчлалын хөтөлбөрийн багш нарын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, судалгааны ажлын үр дүнг хөтөлбөрт хэрхэн тусгагдсан байдлын шинжилгээг хийсэн.

Зөвлөмж:

- Аялал жуулчлалын менежмент хөтөлбөрийн профессор, багш нараас WoS, Scopus – д бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх ажлыг эрчимжүүлэх

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх журам (2019.5.31 А/128), Профессор багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам (2022.1.13 А/05), Профессор багш нарыг аттестатчлах, профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох журам (2013.11.15 А/213)
- Багшийн өөрийн үнэлгээний тайлан (soft file), Оюутны сэтгэл ханамжийн судалгаа (soft file)

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллын механизм цаг үеэ даган өөрчлөгдөж, багш ажилчдад бодит дэмжлэг болж чаддаг.
- Удирдлагын мэдээллийн системээрээ (UNIMIS) дамжуулан багшийн өөрийн үнэлгээний тайланг хүлээн авч, сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг нийтэлж байгаа зэрэг давуу талтай байна.

Анхаарах асуудал:

- ШУТИС-ийн "Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам"-ийн Хүснэгт 4, 5, 6 дагуу шалгуур бүрээр задлан шинжилгээ хийх нь цаашид аль үзүүлэлт давамгайл байгаа аль хоцрогдоод байгааг мэдэх боломжтой төдийгүй ТМС-ийн ажлын төлөвлөгөөнд тусгалаа олж байх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл ӨҮТ-аас аялал жуулчлалын хөтөлбөрийн профессор, багш нар сурталчилгааны өгүүлэл хэвлүүлсэн эсэх, аль ч түвшинд судалгааны ажил удирддаг эсэх нь тодорхойгүй байна.

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан***

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- БШУЯ-ны бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага (2014.4.28 А/174)
- ШУТИС-ийн чанарын бодлого, зорилт (2019.3.22 А/70), ШУТИС-ийн дотоод хяналт шалгалтын журам (2009.5.1/ 162), ШУТИС-ийн хөтөлбөрийн хорооны журам (2017.10.9 А/182)
- ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны гарын авлага (2020.1.20 А/16)
- ШУТИС-ийн чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитийн тайлан 2022
- Өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэх журам (2022.4.5 А/106)

Онцлог зүйл/Туршлага:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн чанарын дотоод баталгаажуулалтын тогтсон механизмтай, орон тооны чанарын менежертэй, чанарын менежментийг дэмжих баг 11 гишүүнтэй ажиллаж байна.
- Чанарын дотоод баталгаажуулалтын бодлогын баримт бичгүүд батлагдаж, тогтвортой хэрэгжиж байна.
- Сургалтын хөтөлбөрийг сайжруулах, оролцогч талуудын эрэлт шаардлагыг хангах, чанарын хяналтыг хөтөлбөрийн дэд хороо хариуцан хийж байна.

Зөвлөмж:

- Чанарын соёлыг байгууллагадаа түгээн дэлгэрүүлэх, таниулж ажлыг эрчимжүүлэх

Шаардлагыг хангасан байдал: Бүрэн хангасан

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн мөшгих судалгаа 2016-2021, Аялал жуулчлалын хөтөлбөрийн төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа 2020 ба 2021, Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа 2020 ба 2021, Оюутны сэтгэл ханамжийн судалгаа 2016-2021, Ажил олгогчийн судалгаа 2021

Онцлог зүйл/Туршлага:

- Чанарын дотоод баталгаажуулалтанд хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талууд оролцоог хангаж, хөтөлбөрт оролцогч талуудаас сэтгэл ханамжийн судалгаа авч хэвшсэн.
- Уг судалгаануудын үр дүн, нийцлийг тодорхойлж, хэрэгжилтийг хянах ажлыг чанарын менежер хариуцан хийдэг.

Зөвлөмж:

- Аялал жуулчлалын хөтөлбөрийн сайжруулалтад төрийн байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг тусгах

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдээлэл 2021
- "Аялал жуулчлалын менежмент" бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн гэрчилгээ (2015 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн 189 тоот)
- ACBSP олон улсын байгууллагаас хүлээн авсан гэрчилгээ (2022.2.25 soft file)

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарыг 2015 онд БМИҮЗ-өөр магадлан итгэмжлүүлсэн.
- 2020 онд ACBSP олон улсын байгууллагад материалаа илгээн хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, 2022 онд гэрчилгээ авсан.
- Хөтөлбөр хариуцсан нэгж ТМС-с 6 багш чанарын сургалтад сууж гэрчилгээ авсан.

Зөвлөмж:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн ахисан түвшинд суралцаж байгаа эсэхийг судалсан судалгааг хийж хэвших

*Шаардлагыг хангасан байдал: **Бүрэн хангасан***

*7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан***

ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Үнэлгээ	Тайлбар
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	Бүрэн хангасан	
2	Сургалтын үйл ажиллагаа	Бүрэн хангасан	
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	Бүрэн хангасан	
4	Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	Бүрэн хангасан	
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	Бүрэн хангасан	
6	Багшийн үйл ажиллагаа	Бүрэн хангасан	
7	Чанарын үнэлгээ баталгаажуулалт	Бүрэн хангасан	
Дүгнэлт		Бүрэн хангасан	

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Биенес удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн **“Аялал жуулчлалын менежмент”** хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ” Бүрэн хангасан** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: М.Хишиг-Ундрах

Шинжээчийн багийн гишүүн: С.Амаржаргал

Шинжээчийн багийн гишүүн: Ц.Дашцэрэн

НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Биенес удирдлага, хүмүүнлэгийн сургууль
Хөтөлбөрийн нэр	“Аялал жуулчлалын менежмент”
Хөтөлбөрийн индекс	D 041304
ЗӨВЛӨМЖ	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> - Гадаад оюутан элсүүлэх бодлого, үе шаттай ажиллах төлөвлөгөө боловсруулах; - Хөтөлбөрийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн шинэлэг, бүтээлч хандлага (инновац)-ыг бий болгох, эрэл хайлт хийх; - Хөтөлбөрт дадлагын төрөл хэлбэр, цагийг нэмэгдүүлэх боломжийг судалж, дадлагын кредит/ цагийг нэмэгдүүлэх; - Аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэж байгаа хөтөлбөрийн онцлогийг харгалзан суралцагчдад англи хэлний хичээлийг тасралтгүй судлах болон 2 хэл үзэж судлах боломжийг судалж, сургалтын төлөвлөгөөнд тусгах;
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн, хичээлийн үр дүнг цогцоор нь үнэлэх арга зүйг сургалтад ашиглах - Заахуйгаас суралцахууд шилжихэд багш нарт зориулсан сургалт, хэлэлцүүлэг хэрхэн явагддаг, туршлагаа хэрхэн солилцож залуу үедээ өвлүүлдэг талаар тусгавал маш олон бүтээлч, сайн туршлага болохоор санаа авах нөхцөл бүрдүүлэх - Оюутны хандлагыг үнэлэх тусгай аргуудаас сургалтад ашиглах
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> - Цахим сургалтыг зохион байгуулахдаа оновчтой, өөрсдийн онцлогт тохирсон платформ ашиглах - Мэргэжлийн хичээлүүдийн үндсэн сурах бичгийн жагсаалтыг нэгтгэж суралцаж буй оюутны хэмжээнд хүрэлцээтэй байгаа эсэхийг жил бүр судлан үзэж, хэрэгцээтэй сурах бичгийн фондыг бий болгох тал дээр төлөвлөж ажиллах;
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> - Төсөл, хөтөлбөрт хамрагдах оюутны оролцоо, тоог нэмэгдүүлэх - Хөтөлбөрөөр суралцагчдад дэмжлэг үзүүлэх санхүүгийн бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх; - Маркетингийн баг сурталчилгаа, идэвхжүүлэлтийн үр дүнд хариу өдөөгдөл хэр илэрч байгааг үнэлдэг байх.
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> - Төгсөгчдийн холбоог идэвхжүүлэх, эргэх холбоогоор сайн хангаж өгөх
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> - Багшлахуйн ур чадвар, судалгааны ур чадвар, суралцах хэрэгцээг тодорхойлсон судалгаа урьдчилан хийдэг болох

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> - Аялал жуулчлалын хөтөлбөрийн сайжруулалтад төрийн байгууллага болон мэргэжлийн холбоодын саналыг тусгах - Хөтөлбөрөөр төгсөгчдийн ахисан түвшинд суралцаж байгаа эсэхийг судалсан судалгааг хийж хэвших
ШААРДЛАГА	
Шаардлага 1.3	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрт дадлагын төрөл хэлбэр, цагийг нэмэгдүүлэх боломжийг судалж, дадлагын кредит цагийг нэмэгдүүлэх - Аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэж байгаа хөтөлбөрийн онцлогийг харгалзан суралцагчдад англи хэлний хичээлийг тасралтгүй судлах болон 2 хэл үзэж судлах боломжийг судалж, сургалтын төлөвлөгөөнд тусгах, хэрэгжүүлэх

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажилла сан жил	Заадаг хичээл
1	Л.Амартүвшин	Салбарын эрхлэгч	Доктор (Ph.D) Дэд профессор	17.5	Аялал жуулчлалын хэрэглэгчдийн зан төлөв, Аялал жуулчлалын маркетинг, Зочид буудлын менежмент D.TM705. Хөрөнгө оруулалт ба санхүүгийн удирдлага
2	Н.Галиймаа	Профессор	Доктор (Ph.D) Профессор	30	Соёлын аялал жуулчлал, Олон улсын аялал жуулчлал
3	Ц.Энхбаатар	Профессор	Доктор (Ph.D) Профессор	33.8	D.SM704- Аюултай тохиолдлын бүртгэл, судалгаа, шинжилгээ
4	Б.Цэцгээ	Профессор	Доктор (Sc.D) Профессор	29.8	D.TM720- Бизнесийн шинжилгээний аргууд D.TM720- Бизнесийн шинжилгээний аргууд 2 S.PS710- Судалгаа шинжилгээний арга зүй
5	Я.Оюунтунгалаг	Профессор	Доктор (Sc.D) Профессор	25.2	B.TM305 Хөдөлмөр зохион байгуулалт B.TM319 Хөнгөн үйлдвэрийн салбарын эдийн засаг B.TM306 Амралт чөлөөт цагийн бизнес B.TM202 Үйлдвэрлэл ү/а-ны менежмент
6	М.Заяа	Дэд профессор	Доктор (Ph.D)	16	B.TM308 Чанарын менежмент D.PQ701 Чанарын удирдлагын тогтолцоо D.TM805 Чанарын шинжилгээ, стандартчилал
7	П.Одмаа	Ахлах багш	Доктор (Ph.D)	18.6	B.TM202 Үйлдвэрлэл ү/а-ны менежмент B.TM316 Үйлдвэрийн төсөл тооцоо B.TM102 Микро эдийн засаг
8	М.Бурмаа	Ахлах багш	Доктор (Ph.D)	17.5	B.TM312 Холбооны компанийн менежмент B.TM103 Макро эдийн засаг D.IM702. Электрон бизнесийн менежмент

9	Т.Сүмжидмаа	Ахлах багш	Доктор (Ph.D)	20	В.ТМ201 Бизнесийн статистик В.ТМ307 Бүтээмжийн менежмент D.ТМ720 Бизнесийн шинжилгээний аргууд В.ТМ373 Мэргэжлийн дадлага В.ТМ371 Хөнгөн үйлдвэр, бизнесийн танилцах дадлага
10	Б.Алтанхуяг	Ахлах багш		15.3	Аялал жуулчлалын менежмент В.ТМ309 Инновацийн менежмент I В.ТМ204 Хөгжлийн эдийн засаг В.ТМ301Т Орчуулагч, хөтчийн үйлчилгээний тех В.ТМ308 Чанарын менежмент В.ТМ317Т Танилцах дадлага /аялал/
11	Д.Төрмөнх	Ахлах багш		34.7	S.PM211 Бизнес систем бүртгэлийн үндэс S.PM101 Эдийн засгийн онолын үндэс В.ТМ372 Үйлдвэрлэлийн дадлага
12	Д.Содномзул	Ахлах багш		20.4	В.ТМ306 Логистикийн менежмент В.ТМ103 Макро эдийн засаг
13	Б.Алтансүвд	Ахлах багш		20.7	S.PM101 Эдийн засгийн онолын үндэс /төв/ U.IT102 Мэдээллийн технологийн хэрэглээ II
14	Д.Алтанцэцэг	Ахлах багш		30.8	В.ТМ103 Макро эдийн засаг S.PM101 Эдийн засгийн онолын үндэс
15	Б.Баттулга	Ахлах багш	Доктор (Ph.D)	16.7	В.ТМ103 Макро эдийн засаг В.ТМ103 Макро эдийн засаг /МехТС/ D.ТМ709 Технологийн хөгжлийн стратеги
16	Ж.Баасангэрэл	Багш		32.7	В.ТМ308Т Хоол ундааны үйлчилгээний менежмент S.PM101 Эдийн засгийн онолын үндэс /Төв/ В.ТМ305Т Зочид буудлын менежмент В.ТМ318Т Мэргэжлийн дадлага /аялал/ В.ТМ390 Бакалаврын диплом нарийн бичиг /ХХМ/
17	Ц.Мөнхсүх	Багш		11	В.ТМ314 Цахим бизнесийн технологиуд В.ТМ202 Үйлдвэрлэл үйл ажиллагааны менежмент В.ТМ369 Үйлдвэрлэлийн дадлага В.ТМ368 Танилцах дадлага /холбоо/
18	Д.Эрдэнэсүрэн	Багш		15.2	В.ТМ206 Жижиг бизнесийн менежмент бухс, мөхт В.ТМ367 Мэргэжлийн дадлага ЖДҮМ В.ТМ366 Менежментийн дадлага ЖДҮМ
19	Ц.Энхтуул	Багш		14.8	Аялал жуулчлалын судалгааны аргууд В.ТМ103 Макро эдийн засаг В.ТМ201 Бизнесийн статистик
20	Б.Энхжаргал	Багш		31.8	S.PM101 Эдийн засгийн онолын үндэс В.ТМ370 Мэргэжлийн дадлага

II. Оюутны нэрс

	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1.	М.Анударь	II	Ангийн дарга учир
2.	Д.Ирмүүн	II	Шилжиж ирсэн тул
3.	Ш.Урангэгээ	II	Малчны хүүхэд
4.	Г.Баасандалай	II	Сурлагаар санамсаргүй түүвэр бүрдүүлсэн
5.	Б.Бадмаараг	II	Хотын хүүхэд тул
6.	Г.Бөртэцэцэн	III	Ангийн дарга тул

7.	Э.Нарангэрэл	III	Оюутны байранд амьдардаг
8.	М.Түмэнжаргалан	III	Ажил хийж өөрөө төлбөрөө олдог
9.	С.Энхжин	III	Хөдөөний хүүхэд
10.	Э.Аргун	III	Сурлагаар санамсаргүй түүвэр бүрдүүлсэн
11.	Ж. Мөнгөнзул	IV	Сурлагаар санамсаргүй түүвэр бүрдүүлсэн
12.	Г. Гантогтох	IV	
13.	Н. Ариунболд	IV	
14.	Н.Солонго	IV	
15.	Э. Хонгорзул	IV	
16.	Д. Золзаяа	Диплом бичиж байгаа	Дотуур байранд амьдардаг

III. Ажил олгогчдын нэрс

Ажил олгогчдын уулзалтад оролцогчдын мэдээлэл

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал	Гарын үсэг
1.	Ц.Оюунбаяр	Нөгө амралтын газар	Захирал	<i>Оюун</i>
2.	Г.Отгонбаатар	Өвөрхангай аймгийн Орхон жуулчны бааз	Захирал	
3.	Н.Сарангарав	ХААИС	Байгалийн аялал жуулчлалын хөтөлбөрийн хорооны зохицуулагч	<i>Оюун</i>
4.	М.Чулуунцэцэг	Грийт Инпайр ХХК	Захирал	
5.	Б.Бямбаа	Нью Жуулчин ХХК	Менежер	
6.	М.Чимидтогтох	Лэйбор Форс	Захирал	<i>М.Чимидтогтох</i>
7.	О.Шинэбаяр	Актив Адвенчур Турс Монголиа ХХК	Аяллын менежер	<i>О.Шинэбаяр</i>
8.	Ж.Сарнай	Эйр Маркет ХХК	Үйлчилгээний зөвлөх	<i>Ж.Сарнай</i>
9.	Т.Очирдарь	Optimal Solutions ХХК	Гүйцэтгэх захирал	
10.	Н.Мөнх-Эрдэнэ	Dream UB Tour ХХК	Гүйцэтгэх захирал	<i>Оюун</i>
11.	Н. Мөнхбаатар	Үлэмж Тур ХХК	Захирал	<i>Оюун</i>
12.	Б.Хишигжаргал	Poly Power Investment	Ерөнхий менежер	<i>Оюун</i>
13.	М.Нямцэрэн	Алибаба ЖДТ Монголий	Ерөнхий менежер	<i>Оюун</i>
14.	<i>О.Очир</i>	<i>Мунгун ХХК</i>	<i>Алива менежер</i>	<i>О.Очир</i>

IV. Төгсөгчдийн нэрс

Төгсөгчдийн уулзалтад оролцогчдын мэдээлэл

Огноо:

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал	Гарын үсэг
1	Д.Тэргэл	2021 ✓	Нью Жуулчин ХХК	Менежер	
2	Н.Маралмаа	2019	Зан Глобал ХХК	Дижитал артист	
3	Ч.Даваажаргал	2020	Сайн электрогикс	Менежер	
4	Т.Эрдэнэбаяр	2020	Best Door	Үйлдвэрийн дарга	
5	О.Амаржаргал	2018	Баян Хайрхан Трейд	Менежер	
6	О.Индраа	2018	Монгол банк	Ерөнхийлөгчийн туслах	
7	Г.Төгстөмөр	2018	Оюу толгой ХХК	ХАБ менежер	
8	Э.Тэргэл	2020	Торгон Тэм ХХК	Үйл ажиллагааны менежер	
9	О.Цацрал	2018	Эдоо гоор байхгүй		
10	Одбилэг	2018	Аялал жуулчлалын үндэсний төв	Мэргэжилтэн	
11	Жавзансүрэн	2022	Aurora Hotel	Хүлээн авагч	
12	Одонтулгал	2021 ✓	Монголын алт корпораци	Борлуулалтын мэргэжилтэн	
13	Т.Очирдарь	2007	Optimal Solutions ХХК	Гүйцэтгэх захирал	
14	Г.Мишээл	2022	Онлайн Нэнтворк ХХК	Маркетингийн менежер /88551793/	
15	Т.Оюундарь	2017	Хөшгийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа ТӨҮГ	Нярав /92018788/	
16	Н.Сүлдболд	2018	Геологийн төв лаборатори ТӨҮГ	Худалдан авалтын мэргэжилтэн	
17	Б.Шошвандан	2007	ХААИС	Аялал жуулчлалын багш	
18	Б.Баянжаргал	2019	Хувираа бизнес		
19	Ц.Энцэнмядаг	2019	Монгол банк	Эрдэнэсийн сангийн үзмэрийн мэргэжилтэн	
20	Г.Золжаргал	2021	Индранил шүдний эмнэлэг	Зохион байгуулагч	
21	О.Лхамсүрэн	2020	Мишээл мега малл	Ресепшин	
22	О.Ингүүн	2021	Худалдаа хөгжлийн банк	Харилцааны мэргэжилтэн	

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал /албан бичгийг оруулах/



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
**БИЗНЕСИЙН УДИРДЛАГА,
ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛЬ**
ШУТИС-ийн V байр, Их тойруу, 2 дугаар хороо,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот 13361, ш/х-49/313
Утас/Факс: (976-11) 45 81 51,
Цахим шуудан: secretary.sbh@must.edu.mn,
Цахим хуудас: www.sbh.edu.mn

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ
ЗӨВЛӨЛД

2022.06.15 № 300
танай _____-ны № _____-г

Шинжээчдийн тайлантай танилцсан
тухай

БМИҮЗ-ийн мэргэжилтэн, шинжээчид БуХС-ийн "Аялал жуулчлалын менежмент" хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн тайлантай танилцлаа.

Шинжээчдийн зүгээс өгсөн хөтөлбөрийн талаарх үнэлэлт, дүгнэлттэй санал нийлж байгаа бөгөөд цаашид хөтөлбөрийг сайжруулах талаар үнэтэй санал, зөвлөмжүүд өгөгдсөн байна. Сургуулийн зүгээс энэхүү санал, зөвлөмжийн дагуу хөтөлбөрийн сургалтын чанар, орчныг сайжруулах талаар тодорхой ажлуудыг сургуулийн мастер төлөвлөгөө, салбар, хөтөлбөрийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөөнүүдэд тусгаж хэрэгжүүлэх замаар сургалтын хөтөлбөрийг тасралтгүй сайжруулах зорилтуудыг ханган ажиллах болно.

Хамтран ажилласан БМИҮЗ, шинжээчдийн багт гүн талархал илэрхийлье!

ЗАХИРАЛ



А.ЭНХБАТ

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 2022.06.23

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа
МАГАДЛАН ИТГЭМЖИЛСЭН	5 ЖИЛ

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа